

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэлд:

“I.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын 2014-2016 оны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуулийн төслийн талаар

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монгол Улсын 2014-2016 оны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.

2. Монгол Улсын 2014-2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2014 оны төсвийн төсөл боловсруулах явцтай уялдуулан төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа зарим хөтөлбөр, арга хэмжээг оновчтой болгох, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнг сайжруулж хэмнэлттэй зохион байгуулах чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав:

2.1. Төсвийн байгууллагуудын урсгал зардал, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, орон тоо, урсгал зардлыг нэмэгдүүлэх үр дагавар бүхий аливаа шийдвэрийг хэрэгжүүлэхдээ ажлын ачааллыг нягтруулах, бүтэц-чиг үүргийг оновчтой тогтоох замаар төсвийн хязгаарт багтаах, шаардлагатай зарим шийдвэрийг дахин хянан өөрчлөх;

2.2. Төсвөөс олгож байгаа татаас, урамшууллын бодлогын хэрэгжилт, үр дүнг үнэлэх замаар эдийн засгийн үр ашигтай, үндэсний аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, цаашид бие даан хөгжих чадавхийг бүрдүүлэхэд илүүтэй чиглүүлэх, хяналт тавих механизмыг бий болгох замаар төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх;

2.3. Төсвөөс нэмэлт санхүүжилт шаардах хөтөлбөр, арга хэмжээг шинээр эхлүүлэхгүй байх төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд одоо хэрэгжиж байгаа хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилттэй уялдуулах, хүрэх үр дүн болон тэргүүлэх ач холбогдлыг харгалзан тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан төсвийн хязгаарт багтаан дахин хуваарилах замаар шийдвэрлэх;

2.4. Төрийн байгууллагын албан хаагчдад ажлын үр дүнтэй нь уялдсан урамшуулал олгох нөхцөл, боломжийг бүрдүүлэх;

2.5. Төрөөс зардлыг нь хариуцаж байгаа зарим хөтөлбөр, арга хэмжээний үр дүн, чанарыг сайжруулах, санхүүжилтийн механизмыг нь оновчтой тогтоох замаар үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулах;

2.6. Улсын төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг Засгийн газрын үнэт цаас борлуулсан орлогоос болон орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжигдэж буй хөрөнгө оруулалттай уялдуулан оновчтой тогтоох.” гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

